


# ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ТӨВИЙН

## ТАЙЛАН


### 1. Зөвлөгөө өгөх төвийн зөвлөгөөний тайлан:

2014-2015 оны хичээлийн жилд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлж, зөвлөгөө авсан оюутан болон гэр бүлүүдийн талаарх мэдээлэл болоод зөвлөгөөний үр дүнг танилцуулав.

#### 1. Зөвлөгөө өгөх төвөөр I улиралд үйлчлүүлсэн хүмүүсийн насны байдал




#### 2. Зөвлөгөө өгөх төвөөр II улиралд үйлчлүүлсэн хүмүүсийн насны байдал




Өмнөх улирлынхтай харьцуулахад насны байдлаар 16-25 насныхан буюу оюутнууд зөвлөгөөний төвд илүү их хандаж үйлчлүүлсэн нь харагдаж байсан. Энэ нь зөвлөгөө өгөх төвийн талаарх мэдээллийг оюутнууд авч эхэлсэн бөгөөд энэ тал дээр илүү нээлттэй болж байгааг илрэл юм.

### 3. Зөвлөгөө өгөх төвд хандсан оюутнуудын курсын байдал



Зөвлөгөө өгөх төвд хандах оюутнуудын анги, курсын байдлаас харахад 2,3-р курсын оюутнууд илүү их ханддаг бөгөөд энэ нь оюутнууд 2,3-р курс дээ цаашдын амьдрал ирээдүйдээ илүү санаа зовох, өөрийн гэсэн зүйлсийг бий болгох гэх мэт санхүү мөнгө болон мэргэжилийн тал дээр анхаарал тавиж эхэлдэг учраас тэдэнд зөвлөх, сэтгэл санааг нь сонсож дэмжих хэрэгцээ шаардлага гардаг.

### 4. Зөвлөгөөний төвөөр үйлчлүүлсэн давтамж



Үйлчлүүлэгч нарын асуудлын түвшнөөс хамааран уулзалтын тоо өөр өөр байдаг. Дийлэнх хүмүүс 2-оос 3 удаа ирж уулздаг бөгөөд тэдгээр уулзалтууд хүмүүсийн өөрсдийнх нь хүсэлтэн дээр тулгуурласан байдаг.

5. Зөвлөгөө өгөх төвд хандах болсон шалтгаан

№	Шалтгаан	Хувь	
1	Үерхэл нөхөрлөл	15%	Хүсээгүй жирэмслэлт
			Үл ойлголцол
			Сексийн харилцааны асуудал
2	Гэр бүл төлөвлөлт	15%	Ирээдүйн ханиа сонгох сонголт
			Найз залуу \охин\ -тойгоо харилцах харилцаагаа сайжруулах арга зам
			Гэрлэлтийн өмнөх хямрал
			Гэр бүл болохоос өмнө хэрхэн өөрийгөө бэлдэх
3	Гэр бүлийн эдийн засгийн асуудал	2%	Орон байрны асуудал \хадмуудтайгаа амьдрах\
			Өрхийн орлого хүрэлцээгүйгээс хямрах стресст орох
			Зөвхөн эхнэр ажиллаж нөхөр ажиллахгүйгээс үүсэх маргаан
4	Гэр бүлийн харилцааны зөрчилдөөн	5%	Хадам эцэг, эх хүргэн бэрийн зөрчилтэй харилцаа
			Ах дүүсийн хооронд үүссэн маргаан
		18%	Хүүхдийн хүмүүжлийн асуудал

5	Эцэг эх – хүүхдийн харилцаанд тулгамдаж буй асуудал		Хүүхдийг өөрийн гэсэн сонирхол хүсэл эрмэлзлэлээ олоход нь туслах
			Эцэг эх хүүхдийн хооронд үүссэн үл ойлголцол
			Эцэг эх үр хүүхдээ ойлгохгүй байх
6	Гэр бүл салалт	4%	Гэр бүлийн харилцаа зөрчилтэй салах талаар бодож эхэлсэн, яах учраа олохгүй байх
			Салалтын өмнөх хямрал
			Салалтын дараах хямрал
			Хүүхдийн хүмүүжлийн асуудал
		Хүүхдийг тэжээн тэтгэх асуудал	
		Хүүхдийн асран хамгаалагчыг тогтоох асуудал	
7	Гэр бүлийн хүчирхийлэл, дарамт шахалт	5%	Хардалтын асуудал
			Нөхөртөө зодуулж, хэл амаар доромжлуулах
			Садан төрлийн хүнээсээ бэлгийн хүчирхийлэл амсах
8	Зан чанарын асуудал	16%	Ганцаардалд орох
			Өөрийгөө голох, өөртөө итгэлгүй болох
			зан үйлийн доголдлоо засах
			Байнгын уурлаж бухимдах
			Стрессээс гарах арга зам
		13%	Хардалт
			Сексийн харилцааны

9	Эхнэр нөхрийн таарамжгүй харилцаа		асуудал
			Үл ойлголцол
			Зан чанарын ялгаатай байдал
			Хүйсийн ялгаатай байдал
			Хэн хэндээ цаг зарцуулахгүй байдал, халамж анхаарал дутах
			Нөхөр \эхнэр \нь гадаад ажиллаж амьдардаг гэр бүлийн асуудал
			Хөдөлмөрийн тэгш бус хувиарлалтын асуудал
Гэр бүлээс гадуурх харилцаа			
10	Архины асуудал	1%	Архины хамааралтай гэр бүлд өсөж буй хүүхдийн хүмүүжлийн асуудал
			Архинаас үүдэлтэй гэр бүлийн санхүүгийн хямрал үүсэх
			Хүчирхийлэл, дарамтанд орох
11	Дахин гэрлэлтийн асуудал	5%	Өмнөх гэрлэлтээс үүссэх хэрүүл маргаан, үл итгэлцэл
			Хүүхдийн хүмүүжлийн асуудал
			Хойд эцэг эх хүүхдийн харилцаанд гарах зөрчил маргаан
			Эд хөрөнгийн асуудал
Бусад садан төрлийн хүмүүстэй зөрчилтэй харилцаа үүсэх			

12	Бусад харилцааны асуудал	22%	Найз нөхдийн хооронд үүссэн үл ойлголцол
			Мэргэжил сонголт
			Хичээлдээ дур сонирхолгүй болох
			Багш болон ангийнхантай ойлголцохгүй байх

Өмнөх улиралд оюутан гэхээс илүү гаднаас ирсэн гэр бүлүүд түлхүү зөвлөгөө авч байсан учраас гэр бүлийн харилцааны зөрчил, салалт зэрэг асуудал илүүтэй байсан. Харин энэ улиралд манай сургуулийн оюутнууд илүү зөвлөгөөний төвд хандсан нь дээрх хүснэгтээс дүгнэхэд илт байна. Оюутнуудад тулгамдаж буй асуудлуудын дийлэнх хувийг эцэг эх, найз нөхөдтэйгээ харилцах харилцаа, мэргэжил боловсролын хувьд үүсэх асуудлууд нь эзэлж байна.

Зөвлөгөө өгөх төвд хандсан оюутнууд болон гэр бүлүүд нь цаашдаа ч энэ төвд хандах, дахин асуудлаа ярилцан зөв шийдлийг олох сонирхолтой байдаг. Нэг удаадаа зөвлөгөө авсан хүн дараагын удаа өөр нэгэн асуудлаар зөвлөгөө авхаар ирдэг нь тэдэнд энэ талын үйлчилгээ, мэдлэг мэдээлэл чухал хэрэгцээ шаардлагатай байгаа нь 2014-2015 оны хичээлийн жилийн хугацаанд зөвлөгөө авсан оюутан залуусаас харагдаж байна. Энэ хичээлийн жилд нийт 151 хүнд дунджаар 226 цагийн зөвлөгөөг өгсөн ба үүнд зөвхөн анхны уулзалтын цагийг хамааруулсан.

## **2. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн сурагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтын тайлан**

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Нийслэлийн боловсролын газартай хамтран ЕБС-н төгсөх ангийн сурагчдад гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 2015 оны 02 сарын 06-ны өдрөөс эхлэн долоо хоногийн 5 дахь өдөр бүр 14 цагаас сургуулийн Б байрны 203 болон 204 тоотод 40 минутын хичээлийг заасан. Гэр бүлийн боловсрол олгох сургалтын дараагаар Олон Улсын Улаанбаатарын Их сургуулийн видео танилцуулга үзүүлэн, мөн сургуулийн танилцуулга тарааж, сурагчдын сургуулийн талаар

асуух асуултанд хариулт өгч байсан. Үүний дараагаар сургуулийн орчинтой танилцуулах

- А- байр. Цайны газар, спорт заал, Интернет төв
- Б-байр. Номын сан, оюутанд зөвлөгөө өгөх төв, бизнес судалгааны төв,

сувилахуйн лаборатори, хөдөө аж ахуйн лаборатори гэсэн маршрутыг зохион байгуулж долоо хоног бүр нэг нэг тэнхимд хариуцуулан өгсөн.

Тус сургалт нь 02 сараас 05 сарыг хүртэлх хугацаанд явагдсан бөгөөд нийт 16 ЕБС-д хамрагдах байснаас 8 сургуулийн 227 сурагч гэр бүлийн боловсрол олгох сургалтанд сууж, ОУУБИС-тай танилцсан байна.

Сургалтанд хамрагдаж чадаагүй үлдсэн 8 ЕБС-н хувьд улсын шалгалтын хугацаа давхцсан, төгсөх ангийн сурагчдын шалгалтууд эхлэсэнтэй холбоотойгоор сургалтыг цуцалсан.

ЕБС-н сурагчдад “Гэр бүлийн боловсрол олгох сургалт”-ыг 8 удаа 40 минутаар буюу нийт 320 минутын хичээлийг заасан. \Сургалтын зураг болон хичээлийг хавсралтаар оруулав.\

### **3. Олон улсын улаанбаатарын их сургуулийн дотуур байрны оюутнуудад зориулсан сургалтын тайлан**

Дотуур байрны 1-4-р курсын 141 оюутанд /давхардсан тоогоор/ 03 сарын 05-аас 04 сарын 16-ныг хүртэл 7 хоногийн Пүрэв гараг бүр 60 минутын “Гэр бүлийн боловсрол олгох” сургалтыг зохион явууллаа. Сургалтыг доорх 7 бүлэг сэдвийн дагуу оюутнуудтай харилцан ярилцах, тэднийг оролцуулах идэвхжүүлэх ажлуудтай хичээллүүдийг заасан.

1. Зорилготой амьдрал
  - Өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх
  - Өөрийн чадвар чадамжаа олж мэдэх
  - Алсын хараа зорилго гэж юу болох хэрхэн тодорхойлох талаар
2. Зуршил ба БИ
  - Зуршил болон хорт зуршил гэж юу болох, хорт зуршлаас сэргийлэх, шинэ зуршил бий болгох.

3. Үерхэл гэж юу вэ? Хэрхэн зөв үерхэх вэ?
  - Үерхэл бол гэрлэлтийн бэлтгэл үе буюу нэг нэгнээ таниж мэдэх алхам юм. Тиймээс бид хэрхэн зөв зүйтэй үерхэх вэ? Үерхэлийн хил хязгаарын талаар дурьдана.
4. Ханиа хэрхэн зөв сонгох вэ?
  - Ирээдүйн ханиа сонгохдоо юу юуг хэрхэн анхааран харах шаардлагатай вэ? Мөн өөрийгөө хэрхэн бэлдэх талаар заах болно. Монголчууд эрт дээр үеэс хүргэн, бэрээ сонгох тал дээр маш нухацтайгаар харж шинждэг байсан уламжлалтай бөгөөд энэ нь ч үр хүүхдийнх нь амьдралд үр өгөөжөө өгдөг нь харагддаг.
5. Бэлгийн амьдрал ба эрэгтэй хүн /зөвхөн эрэгтэй оюутнуудад/
  - Эрэгтэй хүн гэж хэн бэ? Бие сэтгэл зүйн онцлог болоод эрэгтэй хүний бэлгийн амьдрал ба зохистой хугацаа. Гэр бүлийн харилцаанд эрэгтэй хүний эзлэх байр суурь.
6. Бэлгийн амьдрал ба эмэгтэй хүн /зөвхөн эмэгтэй оюутнуудад/
  - Эмэгтэй хүн гэж хэн бэ? Бие сэтгэл зүйн онцлог болоод эмэгтэй хүний бэлгийн амьдрал ба зохистой хугацаа. Гэр бүлийн харилцаанд эмэгтэй хүний эзлэх байр суурь.
7. Гэрлэлт ба аз жаргал
  - Гэр бүл гэж юу вэ? Эхнэр нөхрийн үр хүүхэд болоод өөрсдийнхөө өмнө хүлээх үүрэг хариуцлага, харилцаа хандлага, Гэр бүлийн үнэт зүйл энэ бүгд гэр бүлийн аз жаргалын гол түлхүүр юм.

Сургалтанд дотуур байрны оюутнууд идэвхтэй оролцож байсан. 4-р хичээл буюу ирээдүйн ханиа сонгох сонголтын хичээлээс хойших хичээлүүдэд илүү идэвхтэй оролцож эхэлсэн нь тэдний хувьд гэр бүлээ төлөвлөх, зөв сонголт хийх өөрсдийнх нь ирээдүйн гэр бүлд хэрэгцээ шаардлагатай асуудал болох нь харагдаж байлаа.

Энэхүү хичээлийг цааш улам сайжруулан дотуур байрны оюутнуудад мэдлэг мэдээлэл болгох үүднээс явуулах нь тэднийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалаад зосгохгүй, зорилгодоо хүрэх, ирээдүйн сонголтдоо зөв оновчтой хийхэд нь тус болох юм. \Сургалтын зураг болон хичээлийг хавсралтаар оруулав.\



#### **4. ЕБС-н ахлах ангийн сурагчдын эцэг эхэд зориулсан хүүхдийн хүмүүжлийн сургалт**

Тус сургалтыг БЗД-н 97,87, 79 -р сургуулиудын ахлах ангийн сурагчдын эцэг эхүүдэд 40 минутын хүүхдийг хэрхэн эерэг аргаар хүмүүжүүлэх талаар хичээл заасан. 5 сарын 27-ны 17 цагт 97-р сургуулийн, тус өдрийн 19 цагт 87-р сургуулийн эцэг эхчүүдэд, 5 сарын 29-ны 17 цагт 79-р сургуулийн нийт 110 эцэг эхчүүдэд тус тус хичээл заасан бөгөөд ОУУБИС-н талаар танилцуулсан.

#### **5. ЕБС-н нийгмийн ажилтнуудад зориулсан “Гэр бүлийн сургагч багш бэлтгэх сургалт”**

Монголын Их дээд сургуулийн консорциумтай хамтран зохион байгуулсан ЕБС-н нийгмийн ажилтнуудад зориулсан “Гэр бүлийн сургагч багш бэлтгэх сургалт”-нд оролцсон нийгмийн ажилтнуудыг сургуулийн орчинтой танилцуулах, мэдээлэл өгөх ажлыг хийсэн. Үүний дагуу 4 өртөөгөөр ОУУБИС-г танилцуулах маршрутыг гарган ажилласан.

Олон Улсын Улаанбаатарын Их сургууль танилцуулах маршрут

**Цаг: 12:00-13:00**

1-р өртөө:

УВУ Их сургуулийн В байр:

- Номын сан - 1 давхар
- Оюутанд зөвлөгөө өгөх төв – 2 давхар /206 тоот/
- Бизнес судлалын төв – 3 давхар /310 тоот/
- Сувилахуйн тэнхимийн анги танхим- 4 давхар/412 тоот/
- Их сурхуйн хүрээлэн – 5 давхар
- Хууль эрх зүйн тэнхим \ шүүхийн өрөө\ - 6 давхар /614, 609 тоот/

2-р өртөө:

Оюутны дотуур байр:

- 2 давхарын 201-1 тоотыг үзүүлэх

- Уншлагын танхим /газар доор 1 давхарт байрладаг./

3-р өртөө:

UBU бүрэн дунд сургууль

UBU Бага сургууль

UBU Цэцэрлэг зэргийг танилцуулах.

4-р өртөө:

Оюутны цайны газарт өдрийн хоолонд орох.

#### **6. Эрдэм шинжилгээ судалгааны ажил**

- Олон Улсын Улаанбаатарын Их сургууль Их Сурхуй хүрээлэнгийн нэрэмжит “Залуу судлаач-IV” магистрант, докторантын эрдэм шинжилгээний хуралд “Гэр бүлийн харилцааны маргаанд эвлэрүүлэн зуучлалын үзүүлэх нөлөөлөл” сэдвээр илтгэл тавьсан.
- Нийслэлийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газраас зохион байгуулсан “XXI зуун- Монгол гэр бүл” сэдэвт судлаач, багш нарын хамтарсан эрдэм шинжилгээний бага хуралд оролцон II байр эзэлсэн.
- Монгол гэр бүл сэтгүүлийн 2014 №01 дугаарт “Гэр бүл салалт хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлөх нь” илтгэлийг хэвлүүлсэн
- Монгол гэр бүл сэтгүүлийн 2015 №02 дугаарт “Гэр бүлийн харилцааны маргаанд эвлэрүүлэн зуучлалын үзүүлэх нөлөөлөл” илтгэлийг хэвлүүлсэн.

#### **7. Өөрийгөө хөгжүүлэх ажил**

- ОУУБИС-н Гэр бүл судлалын магистрыг “Гэр бүлийн харилцааны маргаанд эвлэрүүлэн зуучлалын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдвээр дипломын ажлаа хийж хамгаалсан.
- МУИС-н Багшлах эрхийн дээд курст сууж “1-р курсын оюутны түгшүүрийг судласан нь” сэдвээр курсын ажлаа хамгаалсан.

Тайлан бичсэн. Зөвлөгөө өгөх төвийн ажилтан.

Н.Уянга

Хянасан. Оюутны албаны дарга.

Ким Жэ Сон

ДОТУУР БАЙРНЫ ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ҮЙЛ  
ЯВЦЫН ЗУРАГ





ЕБС-Н СУРАГЧДАД ЗОРИУЛСАН “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ  
СУРГАЛТ”-ЫН ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГ

